

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ШШГЕГ-ын 433 дугаар хаалттай хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/233-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
	Утас: 70363040      Цахим хаяг: <a href="mailto:Enkhtuyach@audit.gov.mn">Enkhtuyach@audit.gov.mn</a>
	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 70363036      Цахим хаяг: <a href="mailto:Batmunkhb@audit.gov.mn">Batmunkhb@audit.gov.mn</a>
	Аудитор: З.Золбоо
	Утас: 70362442      Цахим хаяг: <a href="mailto:Zolbooz@audit.gov.mn">Zolbooz@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал, дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4. Материаллаг байдал .....	15
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8. Аудитын гол асуудал .....	18
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт .....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТББ	Төрийн бус байгууллага
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭЯ-2022/233-НА-СТА-ТШЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШШГЕГ-ын 433 дугаар хаалттай хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ШШГЕГ-ын 433 дугаар хаалттай хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

3

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

СЭЯ-2022/233-НА-СТА-ТШЗ

018020088

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

				/ төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>240,375,195.02</b>	<b>232,664,803.41</b>	
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>6,919,325.86</b>	<b>2,466,752.50</b>	
<b>31200</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>6,919,325.86</b>	<b>2,466,752.50</b>	
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>6,919,325.86</b>	<b>2,466,752.50</b>	
31211	Төрийн сангийн харилцах	6,919,325.86	2,466,752.50	
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>2,250,000.00</b>	<b>27,430,400.00</b>	
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	13,715,200.00	
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>2,250,000.00</b>	<b>13,715,200.00</b>	
33510	Байгууллагаас авах авлага	2,250,000.00	13,715,200.00	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>231,205,869.16</b>	<b>202,767,650.91</b>	
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>29,337,808.01</b>	<b>25,121,559.49</b>	
35110	Тусгай зориулалттай материал	26,011,395.00	23,013,380.00	
35130	Эм боох материал	3,326,413.01	2,108,179.49	
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	7,470,161.67	1,149,297.29	
35300	Бэлэн бүтээгдэхүүн	51,114,864.22	64,081,158.15	
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>113,945,035.26</b>	<b>84,751,635.98</b>	
35410	Бичиг хэргийн материал	962,835.00	1,795,918.00	
35420	Аж ахуйн материал	64,534,869.34	38,339,860.54	
35430	Сэлбэг хэрэгсэл	1,579,260.00	1,545,000.00	
35440	Түлш, шатах тослох материал	12,968,115.92	7,758,950.97	
35450	Барилгын засварын материал	8,293,889.51	11,402,675.00	
35460	Хүнсний материал	16,378,976.45	14,300,740.97	
35470	Бусад хангамжийн материал	9,227,089.04	9,608,490.50	
35600	Мал амьтад	29,338,000.00	27,664,000.00	
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,311,954,958.35</b>	<b>6,180,479,804.37</b>	
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>6,311,954,958.35</b>	<b>6,180,479,804.37</b>	
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,231,102,124.81</b>	<b>1,099,939,970.79</b>	
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,412,410,944.92	1,270,336,744.92	
39202	Хуримтлагдсан элэгдэл	(589,360,349.47)	(532,925,051.08)	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	408,309,744.49	391,441,918.49	
39204	Хуримтлагдсан элэгдэл	(219,719,889.41)	(266,468,088.87)	
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	420,199,645.23	430,001,164.01	
39206	Хуримтлагдсан элэгдэл	(252,493,324.32)	(244,755,318.97)	
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,049,275.00	40,575,975.00	
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,049,190.91)	(22,705,375.57)	
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	15,463,660.00	15,463,660.00	
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,837,211.00	38,576,300.00	
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,545,601.72)	(19,601,957.14)	
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>5,080,852,833.54</b>	<b>5,080,539,833.58</b>	
39301	Программ хангамж	4,437,692.31	4,437,692.31	
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,924,858.77)	(3,237,858.73)	
39303	Бусад биет бус хөрөнгө	5,079,340,000.00	5,079,340,000.00	
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>6,552,330,153.37</b>	<b>6,413,144,607.78</b>	
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>6,919,325.86</b>	<b>2,466,752.50</b>	
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>6,919,325.86</b>	<b>2,466,752.50</b>	
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>6,919,325.86</b>	<b>2,466,752.50</b>	
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>6,919,325.86</b>	<b>2,466,752.50</b>	

41362	Хувь хүмүүст төлөх өглөг	6,919,325.86	2,466,752.50
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,545,410,827.51</b>	<b>6,410,677,855.28</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>6,545,410,827.51</b>	<b>6,410,677,855.28</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,354,710,670.66	5,354,710,670.66
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>311,923,016.88</b>	<b>177,190,044.65</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	495,492,311.28	311,923,016.88
51220	Тайлант үеийн үр дүн	(183,569,294.40)	(134,732,972.23)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	878,777,139.97	878,777,139.97
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>6,552,330,153.37</b>	<b>6,413,144,607.78</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,982,711,229.14</b>	<b>2,101,424,564.53</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>378,684,629.14</b>	<b>423,970,764.53</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>378,684,629.14</b>	<b>423,970,764.53</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>280,961,582.14</b>	<b>354,821,486.53</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,922,500.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	248,210,629.00	289,232,988.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,828,453.14	65,588,498.53
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	39,933,000.00	12,651,230.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	57,790,047.00	56,498,048.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,604,026,600.00</b>	<b>1,677,453,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,604,026,600.00</b>	<b>1,677,055,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,604,026,600.00	1,677,055,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>397,900.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	397,900.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,163,427,523.54</b>	<b>2,230,648,692.93</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,163,427,523.54</b>	<b>2,230,648,692.93</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,065,526,527.10</b>	<b>2,137,903,930.97</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,113,197,884.70</b>	<b>1,141,721,534.04</b>
210101	Үндсэн цалин	675,264,015.10	620,438,243.79
210102	Нэмэгдэл	436,933,869.60	521,283,290.25
210104	Урамшуулал	1,000,000.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>23,665,035.16</b>	<b>24,631,155.94</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	23,665,035.16	24,631,155.94
<b>-2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>172,807,493.56</b>	<b>168,947,554.72</b>
210301	Гэрэл, цахилгаан	96,236,606.00	102,956,020.00
210302	Түлш, халаалт	74,998,387.56	65,991,534.72
210303	Цэвэр, бохир ус	1,572,500.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>200,225,649.04</b>	<b>177,740,081.98</b>
210401	Бичиг хэрэг	4,254,907.00	3,733,031.00
210402	Тээвэр, шатахуун	39,588,125.80	40,931,448.02

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,343,255.24	4,205,560.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	186,000.00	160,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,213,884.00	5,967,668.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	136,061,881.02	103,552,623.57
210408	Бараа материал акталсны зардал	10,577,595.98	19,189,451.39
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>291,700,506.24</b>	<b>317,660,054.56</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,460,787.00	25,480,343.52
210502	Хоол, хүнс	234,390,729.14	263,891,662.04
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	38,848,990.10	28,288,049.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>43,512,739.60</b>	<b>67,702,875.80</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,283,200.00	924,250.00
210604	Урсгал засвар	42,229,539.60	66,778,625.80
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>341,000.00</b>	<b>190,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	341,000.00	190,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,291,405.00</b>	<b>7,510,438.85</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,165,500.00	4,681,053.85
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	668,250.00	556,875.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	461,744.00	371,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	220,000.00	187,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,125,100.00	668,200.00
210807	Газрын төлбөр	1,046,011.00	1,046,010.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>213,784,813.80</b>	<b>231,800,235.08</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,744,158.03	11,525,912.72
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	900,030.00	561,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	198,140,625.77	219,712,522.36
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>97,900,996.44</b>	<b>92,744,761.96</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>23,209,200.00</b>	<b>25,662,000.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	23,209,200.00	25,662,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>22,396,920.82</b>	<b>9,623,400.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	258,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,396,920.82	9,365,400.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>278,651.62</b>	<b>1,054,923.96</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	278,651.62	1,054,923.96
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>52,016,224.00</b>	<b>56,404,438.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,016,224.00	56,404,438.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(180,716,294.40)</b>	<b>(129,224,128.40)</b>

<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,853,000.00</b>	<b>5,508,843.83</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	5,508,843.83
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	2,853,000.00	-
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(183,569,294.40)</b>	<b>(134,732,972.23)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	495,492,311.28	6,728,980,121.91
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	495,492,311.28	6,728,980,121.91
4	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
5	Тайлант үеийн үр дүн	-	-	(183,569,294.40)	(183,569,294.40)
6	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	311,923,016.88	6,545,410,827.51
7	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	311,923,016.88	6,545,410,827.51
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	311,923,016.88	6,545,410,827.51
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(134,732,972.23)	(134,732,972.23)
10	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	177,190,044.65	6,410,677,855.28

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,969,295,915.82</b>	<b>2,104,864,289.27</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>365,269,315.82</b>	<b>427,410,489.27</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>365,269,315.82</b>	<b>427,410,489.27</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>365,269,315.82</b>	<b>407,627,289.27</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,922,500.00	79,376,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	348,346,815.82	328,250,789.27
120009	Бусад орлого	-	19,783,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,604,026,600.00</b>	<b>1,677,453,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,604,026,600.00</b>	<b>1,677,055,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,604,026,600.00	1,677,055,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>397,900.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	397,900.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,951,402,381.87</b>	<b>2,075,099,280.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,951,402,381.87</b>	<b>2,075,099,280.42</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,854,032,906.25</b>	<b>1,968,897,318.46</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,113,197,884.70</b>	<b>1,147,789,534.04</b>
210101	Үндсэн цалин	675,264,015.10	620,438,243.79
210102	Нэмэгдэл	436,933,869.60	527,351,290.25
210104	Урамшуулал	1,000,000.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>23,665,035.16</b>	<b>24,631,155.94</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	23,665,035.16	24,631,155.94
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>163,117,568.28</b>	<b>159,143,900.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	96,236,606.00	102,956,020.00
210302	Түлш, халаалт	65,212,962.28	56,187,880.00
210303	Цэвэр, бохир ус	1,668,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>81,088,755.24</b>	<b>75,033,824.00</b>
210401	Бичиг хэрэг	4,325,700.00	3,253,464.00
210402	Тээвэр, шатахуун	67,424,300.00	63,325,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,343,255.24	4,363,560.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	205,700.00	185,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,789,800.00	3,906,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>235,327,500.00</b>	<b>255,677,255.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,725,800.00	23,498,800.00
210502	Хоол, хүнс	216,601,700.00	232,178,455.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>46,002,750.00</b>	<b>88,396,636.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,719,450.00	27,430,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,439,500.00	1,380,300.00
210604	Урсгал засвар	37,843,800.00	59,585,936.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>341,000.00</b>	<b>190,000.00</b>
210702	Дотоод албан томилот	341,000.00	190,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>150,880,912.87</b>	<b>161,452,713.48</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	146,755,007.87	158,623,328.48

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	668,250.00	556,875.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	461,744.00	371,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.00	187,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,125,100.00	668,200.00
210807	Газрын төлбөр	1,046,011.00	1,046,010.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>40,411,500.00</b>	<b>56,582,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,511,500.00	55,802,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	900,000.00	780,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>97,369,475.62</b>	<b>106,201,961.96</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>23,209,200.00</b>	<b>25,662,000.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	23,209,200.00	25,662,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,865,400.00</b>	<b>9,365,400.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,865,400.00	9,365,400.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>278,651.62</b>	<b>14,770,123.96</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	278,651.62	14,770,123.96
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>52,016,224.00</b>	<b>56,404,438.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,016,224.00	56,404,438.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>17,893,533.95</b>	<b>29,765,008.85</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>13,913,550.00</b>	<b>34,217,582.21</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>13,913,550.00</b>	<b>34,217,582.21</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>13,913,550.00</b>	<b>34,217,582.21</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,913,550.00	34,217,582.21
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(13,913,550.00)</b>	<b>(34,217,582.21)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>3,979,983.95</b>	<b>(4,452,573.36)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,939,341.91	6,919,325.86
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,919,325.86	2,466,752.50

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,908,920,600.00</b>	<b>1,894,150,476.04</b>	14,770,123.96	99.23
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,908,920,600.00</b>	<b>1,894,150,476.04</b>	14,770,123.96	99.23
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,879,888,000.00</b>	<b>1,865,191,076.04</b>	14,696,923.96	99.22
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,148,016,100.00</b>	<b>1,147,789,534.04</b>	226,565.96	99.98
210101	Үндсэн цалин	688,472,400.00	620,438,243.79	68,034,156.21	90.12
210102	Нэмэгдэл	455,559,700.00	527,351,290.25	(71,791,590.25)	115.76
210104	Урамшуулал	3,984,000.00	-	3,984,000.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>25,380,400.00</b>	<b>24,631,155.94</b>	749,244.06	97.05

210205	Эрүүл мэндийн даатгал	25,380,400.00	24,631,155.94	749,244.06	97.05
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>159,143,900.00</b>	<b>159,143,900.00</b>	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	102,906,900.00	102,956,020.00	(49,120.00)	100.05
210302	Түлш, халаалт	56,237,000.00	56,187,880.00	49,120.00	99.91
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>74,763,000.00</b>	<b>74,762,324.00</b>	676.00	100.00
210401	Бичиг хэрэг	3,111,000.00	3,110,964.00	36.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	63,196,200.00	63,196,200.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,364,200.00	4,363,560.00	640.00	99.99
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	185,200.00	185,200.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,906,400.00	3,906,400.00	-	100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>255,551,600.00</b>	<b>255,550,855.00</b>	745.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,498,800.00	23,498,800.00	-	100.00
210502	Хоол, хүнс	232,052,800.00	232,052,055.00	745.00	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>122,614,300.00</b>	<b>108,899,018.21</b>	13,715,281.79	88.81
210601	Багаж, техник, хэрэгсэл	61,648,000.00	47,932,782.21	13,715,217.79	77.75
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,380,300.00	1,380,300.00	-	100.00
210604	Урсгал засвар	59,586,000.00	59,585,936.00	64.00	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>190,000.00</b>	<b>190,000.00</b>	-	100.00
210702	Дотоод албан томилолт	190,000.00	190,000.00	-	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>37,646,400.00</b>	<b>37,641,988.85</b>	4,411.15	99.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,816,900.00	34,812,603.85	4,296.15	99.99
210803	Даатгалын үйлчилгээ	556,900.00	556,875.00	25.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	371,300.00	371,300.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	187,000.00	187,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	668,200.00	668,200.00	-	100.00
210807	Газрын төлбөр	1,046,100.00	1,046,010.00	90.00	99.99
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>56,582,300.00</b>	<b>56,582,300.00</b>	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,802,300.00	55,802,300.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	780,000.00	780,000.00	-	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>29,032,600.00</b>	<b>28,959,400.00</b>	73,200.00	99.75
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>25,735,200.00</b>	<b>25,662,000.00</b>	73,200.00	99.72

213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	25,735,200.00	25,662,000.00	73,200.00	99.72
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,297,400.00</b>	<b>3,297,400.00</b>	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,297,400.00	3,297,400.00	-	100.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,908,920,600.00</b>	<b>1,908,177,861.33</b>	742,738.67	99.96
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,677,055,900.00</b>	<b>1,676,313,161.33</b>	742,738.67	99.96
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,677,055,900.00	1,676,313,161.33	742,738.67	99.96
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>231,864,700.00</b>	<b>231,864,700.00</b>	-	100.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,376,500.00	79,376,500.00	-	100.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	152,488,200.00	152,488,200.00	-	100.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>167.00</b>	<b>159.00</b>	8.00	95.21
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>83.00</b>	<b>79.00</b>	4.00	95.18
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	80.00	77.00	3.00	96.25
620003	Үйлчлэх ажилтан	2.00	1.00	1.00	50.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>83.00</b>	<b>79.00</b>	4.00	95.18
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	83.00	79.00	4.00	95.18

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>397,900.00</b>	<b>397,900.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>397,900.00</b>	<b>397,900.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>271,500.00</b>	<b>271,500.00</b>
210401	Бичиг хэрэг	142,500.00	142,500.00
210402	Тээвэр, шатахуун	129,000.00	129,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>126,400.00</b>	<b>126,400.00</b>
210502	Хоол, хүнс	126,400.00	126,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	397,900.00	397,900.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>397,900.00</b>	<b>397,900.00</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу ШШГЕГ-ын 433 дугаар хаалттай хорих анги /цаашид 433 дугаар хаалттай хорих анги гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэж байх, шатахууны тооцооны хуудсыг автомашин ашигласан албан хаагчийн гарын үсгээр баталгаажуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Золбоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

433 дугаар хаалттай хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/96 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

433 дугаар хаалттай хорих ангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалах энэхүү үүргийг бүрэн хэрэгжүүлэх,
- Хорих болон хорихоос өөр төрлийн ялыг албадан эдлүүлэх, сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, эрүүгийн ялын зорилтыг хангах,
- Иргэний, захиргааны зөрчлийн болон эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах мэргэшүүлж, алба хаах нөхцөл, аюулгүй байдал, нийгмийн баталгааг хангах;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын анги, салбар нэгжийн барилга байгууламж, ахуй нөхцөлийг олон улсын жишигт хүргэх,
- Шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа хэвийн явагдах техник, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл болон материаллаг бааз суурийг бэхжүүлэх,

- Үйлдвэрлэлийг хөгжүүлэн үйл ажиллагааных нь үр дүнд хорих ял эдлэгсдийг ажлын байраар хангах, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийг түшиглэсэн үйлдвэр, үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх замаар дотоод эх үүсвэрийг бий болгох.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэж байна.

Тус төвийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны 12 дугаар сард ШШГЕГ-аас “433 дугаар хаалттай хорих ангийн үйл ажиллагаа, хууль, дүрэм журмын хүрээнд явагдаж байгаа эсэх”-д төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдсэн бөгөөд шалгалтын нэгдсэн дүнгээр “Хангалттай” үнэлгээ авсан байна. Тус ангид төлөвлөгөөт шалгалтаар илэрсэн 29 зөрчил дутагдлыг арилгуулахаар 2 сарын хугацаатай үүргийг хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

433 дугаар хаалттай хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 2,163,427.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 21,634.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 16,225.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

433 дугаар хаалттай хорих ангийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 139,185.5 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,919.3	2,466.8	(4,452.5)
Авлага	2,250.0	13,715.2	11,465.2
Урьдчилгаа	-	13,715.2	13,715.2
Бараа материал	231,205.9	202,767.6	(28,438.3)
Үндсэн хөрөнгө	6,311,954.9	6,180,479.8	(131,475.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,552,330.1</b>	<b>6,413,144.6</b>	<b>(139,185.5)</b>
Өр төлбөр	6,919.3	2,466.7	(4,452.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,545,410.8	6,410,677.8	(134,733.0)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>6,552,330.1</b>	<b>6,413,144.6</b>	<b>(139,185.5)</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,466.8 мянган төгрөг болж өмнөх оноос 4,452.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд хоригдлын нэрийн дансанд байрших мөнгөний үлдэгдэл буурснаас шалтгаалжээ.

Авлагын дансны үлдэгдэл 13,715.2 мянган төгрөг болж 11,465.2 мянган төгрөгөөр өссөн нь “Усны хайгуул, худаг өрөмдөж тоноглох” төсөл арга хэмжээний

үлдэгдэл санхүүжилтийг оны эцэст татан төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгүүлснээс шалтгаалсан байна.

Урьдчилгаа данс 13,715.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 21/18 дугаар “Усны хайгуул, худаг өрөмдөж тоноглох” ажил гүйцэтгэх гэрээт ажлын урьдчилгаа 50 хувийн санхүүжилтийг Монтегео ХХК-д шилжүүлснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 202,767.6 мянган төгрөг болж 28,438.3 мянган төгрөгөөр буурсан нь ШШГЕГ-аас 50,311.4 мянган төгрөгийн, дотоодын анги салбараас 7,348.6 мянган төгрөгийн материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, Сод монгол ХХК-с 3,987.3 мянган төгрөгийн шатахууны урамшуулал авсан, төсвийн хөрөнгөөр 501,203.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 746,429.3 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулан, 19,189.4 мянган төгрөгийн материалыг акталж устгасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 7,270,173.5 мянган төгрөг болж өмнөх оноос 153,874.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 34,217.6 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан болон ШШГЕГ-аас 47,078.6 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан, “Хичээнгүй ирээдүй гэгээ” ТББ-аас 9,150.0 мянган төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг хандиваар авч, 3,300.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын данснаас шилжүүлэн бүртгэж, 247,620.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,466.7 мянган төгрөг болж 4,452.6 мянган төгрөгөөр буурсан нь ялтны нэрийн дансны үлдэгдэл буурснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,410,677.8 мянган төгрөг болж 134,733.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

433 дугаар хаалттай хорих ангийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 118,713.3 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар өссөн нь туслах үйл ажиллагааны орлого болон үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өссөнтэй холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 67,221.1 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал болон нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардал өссөнөөс голлон шалтгаалсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг тус бүр 2,228,502.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 319,581.6 мянган төгрөгөөр бууруулж, 1,908,920.6 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь нормативт зардлыг 239,552.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийг 51,548.6 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталснаас голлон шалтгаалсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр **1,908,920.6** мянган төгрөгийн төсөв баталснаас 1,677,055.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 231,864.7 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,677,055.9 мянган төгрөгийн санхүүжилт, үйл ажиллагааны орлогоос 288,269.1 мянган төгрөг, нийт **1,965,325.0** мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд **1,894,150.5** мянган төгрөгийг зарцуулан, төлөвлөгөөнөөс давсан орлого 56,404.4 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчид шилжүүлж, 13,715.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлж татаас санхүүжилтийн авлагаар тайлагнасан бөгөөд төсвийн хэмнэлт 1,054.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,894,150.5** мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь эд хогшил, урсгал засварын зардал хэмнэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

ШШГЕГ-ын даргын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/11 дүгээр тушаалын дагуу төрийн санд 100130412506 тоот "Ахмадын сан"-ийн данс нээж цалингийн зардлаас 6,068.0 мянган төгрөгийг шилжүүлж, ахмадуудад нэг удаагийн буцалтгүй тусламж олгон, оны эцэст үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус төвийн нэмэлт санхүүжилтийн дансанд ШШГЕГ-аас 397.9 мянган төгрөгийн "Өршөөлийн хуулийг хэрэгжүүлэх" зардал шилжүүлснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайлан орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1. ШШГЕГ-ын даргын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/11 дүгээр тушаалын дагуу төрийн санд 100130412506 тоот “Ахмадын сан”-ийн данс нээж цалингийн зардлаас тухайн жилийн төсөвт тусгагдаагүй 6,068.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байгаа нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь **“Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана”** гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд дээрх хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор ахмадын санд төвлөрүүлэх хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгуулж батлуулсны үндсэн дээр санхүүжүүлэх шаардлагатай байна.

3.7.2 Тайлант оны эцэст ШШГЕГ-аас **“Усны хайгуул хийж, худаг өрөмдөж тоноглох, ажил гүйцэтгэх”** 27,430.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний санхүүжилт оны эцэст орж ирснээс уг төсөл арга хэмжээг хэрэгжүүлж амжилгүйгээр 13,715.2 мянган төгрөгийг гэрээт компанид шилжүүлэн урьдчилж гарсан зардлаар, 13,715.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.8 дахь **“Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”** гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул цаашид дээд шатны төсвийн зарирагчийн зүгээс төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх боломжит хугацаанд нь / худалдан авах ажиллагаа зохион байгуулах, төсөл арга хэмжээг хэрэгжүүлж дуусах хугацааг тооцох / санхүүжилтийг олгож, авлага үүсгэхгүй ажиллахад анхаарах шаардлагатай байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан **“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”**-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

433 дугаар хаалттай хорих анги нь шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 143 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн бол 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх онд өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 6736.9 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага өгч, 1,800 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	6,736.9	1	6,736.9	100
Зөвлөмж	4	1,800.0	4	1,800.0	100
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>8,536.9</b>	<b>5</b>	<b>8,536.9</b>	<b>100</b>

/мянган төгрөг/

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан санхүүгийн тайлангийн аудитаар бүх ажил гүйлгээг тулган баталгаажуулах боломжгүй байсан тул туслах аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт, өртөг зардлыг дараагийн аудитаар нарийвчлан авч үзэх шаардлагатай.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 117,410.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 3 зөвлөмж өглөө.

### 4.1 Зөвлөмж

Аудитаар 2 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

#### 1.Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 117,410.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтын и-баримт бөөн дүнгээр цахим системд шивэгдсэн бөгөөд зарим худалдан авалтууд цахим төлбөрийн баримтаар баталгаажгаагүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар

төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## 2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Жолоочийн тооцооны хуудсыг автомашин ашигласан албан тушаалтны гарын үсгээр бус жолоочийн гарын үсэг зурагдсан түлш, шатахууны зарцуулалтыг хянаж, бүртгэл тайланд тусгасан байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно...” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.4 дэх “... Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана.” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид автомашин ашигласан албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан жолоочийн тооцооны хуудсыг үндэслэж шатахууны тооцоог хийж байх.

## 3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Шилэн дансанд мэдээлбэл зохих 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.10 дахь заалтуудыг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	ШШГЕГ-ын 433 дугаар хаалттай хорих анги	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
3	117,410.1	-	-	-	-	-	-	-	-	3	117,410.1